



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 215

Улаанбаатар хот

Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон, нийт 5,347,756,352.00 (таван тэрбум гурван зуун дөчин долоон сая долоон зуун тавин зургаан мянга гурван зуун тавин хоёр) төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан эзэмшигчийг тогтоох, хөрөнгийг хүлээлцэх, бүртгэх, асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132030829
10-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 01 дугаар сарын 27-ны/ний өдрийн
01.27 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРЬСАН
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	Улаанбаатар, Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Гачуурт тосгоны Эрүүл мэндийн төвийн барилга. (УБ хот, БЗД, 20-р хороо, Эрүүл мэндийн төвийн өөрийн эзэмшлийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, зоорьгүй, 2 давхар, тэнхлэгээрээ 36.4м*14.8м, (гадна цахилгаан 0.4 болон 10кВа кабель, дулаан, цэвэр, бохирын шугам,холбоо, гадна гэрэлтүүлэг, явган болон авто зам, талбай, сүүдрэвч, сандал, хашаа, дэд өртөөний барилга, дэд өртөөний цахилгаан)	3,061,200,000.00	2025.02.06	БА-04/5/2025	Нийслэлийн өмчийн харилцааны газар (Улаанбаатар, Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Гачуурт тосгоны Эрүүл мэндийн төвийн барилга)
2	Говь-Алтай аймгийн Цогт сум дахь Баянтоорой тосгон дахь Эрүүл мэндийн төвийн өөрийн эзэмшлийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, 10 ортой барилга, зоорьгүй, 2 давхар, тэнхлэгээрээ 20.4.0м*12.4м, (гүний худаг, бохирын шунам, цооног, КТПН, цахилгааны 0.4дВа шугам, дизель генератор 50кВа, гадна гэрэлтүүлэгийн шон, явган зам,хашаа, бусад)	2,286,556,352.00	2023.12.04	ГАА-КД-31/2023	Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газар (Говь-Алтай аймгийн Цогт сум дахь Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төв)
НИЙТ ДҮН			5,347,756,352.00			
			(таван тэрбум гурван зуун дөчин долоон сая долоон зуун тавин зургаан мянга гурван зуун тавин хоёр)			